



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
ДАШЗЭГВИЙН АМАРБАЯСГАЛАН
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Сүхбаатарын ЭРДЭНЭБОЛД

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д. Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-27-07, Факс: 32-70-16
E-mail: erdenebold@parliament.mn
http://www.parliament.mn

2024.12.13 № 41X-03/4343
танай _____-ны № _____-т

Тогтоолын төсөл өргөн
мэдүүлэх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд "Монгол Улсын төр, нийгмийн нэрт зүтгэлтэн Жамсрангийн Самбуугийн мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын нэр бүхий гишүүд санаачлан боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Тогтоолын төслийг Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Хүндэтгэсэн,

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

С.ЭРДЭНЭБОЛД

Д.БАТБАЯР

П.ГАНЗОРИГ

У.ОТГОНБАЯР

Д.ПҮРЭВДАВАА

Д.РЭГДЭЛ

Ц.ТУВААН

0000000549

УИХ-ын гишүүд:

Ж.Алдаржавхлан

О.Алтангэрэл

Н.Алтанхуяг

Н.Алтаншагай

Д.Амарбаясгалан

С.Амарсайхан

О.Амгаланбаатар

Ч.Анар

А.Ариунзаяа

Т.Аубакир

Х.Баасанжаргал

Ц.Баатархүү

М.Бадамсүрэн

Э.Бат-Амгалан

Б.Батбаатар

Д.Батбаяр

Р.Батболд

Ж.Батжаргал

Д.Батлут

О.Батнайрамдал

Ж.Батсуурь

Н.Батсүмбэрэл

Х.Баттулга

Б.Батцэцэг

П.Батчимэг

Э.Батшугар

Б.Бат-Эрдэнэ

Ж.Бат-Эрдэнэ

Б.Баярбаатар

Ж.Баярмаа

Ж.Баясгалан

0000000549



Б.Бейсен

Х.Болормаа

Э.Болормаа

Х.Булгантуяа

Д.Бум-Очир

Ш.Бямбасүрэн

С.Бямбацогт

Ж.Галбадрах

А.Ганбаатар

Г. Ганбаатар

С.Ганбаатар

Ж.Ганбаатар

Д.Ганбат

П.Ганзориг

Д.Ганмаа

Л.Гантөмөр

Х.Ганжуяа

М.Ганхүлэг

Ц.Даваасүрэн

Г.Дамдинням

Т.Доржханд

Б.Дэлгэрсайхан

Б.Жавхлан

Х.Жангабыл

Б.Жаргалан

Д.Жаргалсайхан

С.Замира

Б.Заяабал

Ж.Золжаргал

С.Зулпхар

Ц.Идэрбат

Ч.Лодойсамбуу

Г.Лувсанжамц











C. eff

С.Лүндэг

М.Мандхай

Л.Мөнхбаатар

Ц.Мөнхбат

Л.Мөнхбаясгалан

Т.Мөнхсайхан

Б.Мөнхсоёл

П.Мөнхтулга

Ц.Мөнхтуяа

З.Мэндсайхан

Б.Найдалаа

Н.Наранбаатар

П.Наранбаяр

М.Нарантуяа

Ч.Номин

О.Номинчимэг

Н.Номтойбаяр

Э.Одбаяр

С.Одонтуяа

У.Отгонбаяр

Г.Очирбат

Л.Оюун-Эрдэнэ

Б.Пунсалмаа

Д.Пүрэвдаваа

Б.Пүрэвдорж

Д.Рэгдэл

П.Сайнзориг

Ц.Сандаг-Очир

О.Саранчулуун

М.Сарнай

Л.Соронзонболд

Р.Сэддорж

Ц.Туваан

0000000549

Б.Тулга

Б.Түвшин

Г.Тэмүүлэн

Х.Тэмүүжин

А.Ундраа

Ч.Ундрал

Н.Учрал

Б.Уянга

Г.Уянгахишиг

Д.Үүрийнтуяа

Г.Хосбаяр

Б.Хэрлэн

Д.Цогтбаатар

Д.Цогтбаатар

О.Цогтгэрэл

С.Цэнгүүн

Ж.Чинбүрэн

Б.Чойжилсүрэн

Ө.Шижир

Л.Энх-Амгалан

Б.Энхбаяр

Ж.Энхбаяр

Л.Энхнасан

Д.Энхтуяа

Д.Энхтүвшин

М.Энхцэцэг

С.Эрдэнэбат

Р.Эрдэнэбүрэн

0000000549



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Сүхбаатарын ЭРДЭНЭБОЛД

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-27-07, Факс: 32-70-16
E-mail: erdenebold@parliament.mn
<http://www.parliament.mn>

2024. 12.11 № 4090-03/7191
танай _____-ны № _____-т

Тогтоолын төсөл өргөн мэдүүлэх
хугацааг товлох тухай

Монгол Улсын төр, нийгмийн нэрт зүтгэлтэн Жамсрангийн Самбуугийн мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай тогтоолын төслийг Улсын Их Хурлын нэр бүхий гишүүд санаачлан боловсруулж, Засгийн газраас санал авч, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.

Хавсралт 18 хуудастай.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

С.ЭРДЭНЭБОЛД

0000000542



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
С.ЭРДЭНЭБОЛД ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn


2024.09.27 № ХЭГ/1829
танай _____-ны № _____-т

Хуралдааны тэмдэглэл
хүргүүлэх тухай

Таны санаачлан боловсруулсан “Жамсрангийн Самбуугийн мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн тэмдэглэлийг хүргүүлж байна.

Хүлээн авч, танилцана уу.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Н.УЧРАЛ

000245018054

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн хуралдааны 34 дүгээр тэмдэглэлд:


“11.ХЭЛЭЛЦСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболдын санаачлан боловсруулсан “Жамсрангийн Самбуугийн мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболдын санаачлан боловсруулсан “Жамсрангийн Самбуугийн мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцээд дараах саналыг төсөл санаачлагчид уламжлахаар тогтов:

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 36.1.2-т “Төсвийн хүрээний мэдэгдэл, улсын төсөв, түүний гүйцэтгэл, хөгжлийн бодлогын болон төлөвлөлтийн баримт бичиг, түүнчлэн өмч, татвар, эрүү, иргэн, захиргааны ерөнхий болон зөрчлийн тухай анхдагч хууль, шинэчилсэн найруулга болон Засгийн газар санаачлахаар Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд тусгайлан заасан асуудлаар хууль тогтоомжийн төслийг зөвхөн Засгийн газар санаачлах.” гэж хууль санаачлах эрхийн хүрээ хязгаарыг тогтоосон бөгөөд Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5.2-т “Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдээс бусад ой, түүхэн үйл явдал, салбарын болон зарим ажил мэргэжлийн ажилтан, ажилчдын өдөр, энэ хуульд зааснаас бусад олон улсын байгууллагаас дэлхий нийтээр тэмдэглэхээр тогтсон тэмдэглэлт өдрийг Засгийн газар тогтооно.” гэж заасан.

Мөн “Журам батлах тухай” Засгийн газрын 2019 оны 204 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх журам”-ын 1.5.1-д “Шинжлэх ухааны академийн дүгнэлт, соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн, Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийн жагсаалтад ороогүй түүхэн үйл явдал, түүхэн хүний тэгш ойг;” тэмдэглэх асуудлыг Засгийн газар шийдвэрлэхээр, мөн журмын 1.7-д “Монгол Улсын баатар, Хөдөлмөрийн баатрыг алдаршуулах, дурсгалыг нь мөнхжүүлэх зорилгоор түүний тэгш ойг тэмдэглэх асуудлыг тухайн салбарын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн шийдвэрлэнэ.” гэж тус тус тусгасан.

Иймд түүхэн хүний тэгш ой буюу Жамсрангийн Самбуугийн мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх асуудлыг Шинжлэх ухааны академийн дүгнэлт, соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар шийдвэрлэхээр байгааг анхаарах нь зүйтэй.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

БАТЛАВ.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

С.ЭРДЭНЭБОЛД

**“ЖАМСРАНГИЙН САМБУУГИЙН МЭНДЭЛСНИЙ 130 ЖИЛИЙН ОЙГ
ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭХ ТАЛААР АВАХ ЗАРИМ АРГА
ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН
ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Тогтоолын төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Улсын Их Хурал төрийн дотоод, гадаад бодлогын аль ч асуудлыг санаачлан хэлэлцэж болох бөгөөд дараах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ”, Гучин наймдугаар зүйлийн 38.2.1 дэх заалтад “Үндсэн хууль, бусад хуулийн биелэлтийг улс даяар зохион байгуулж хангах” гэж заасан байдаг.

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэгт “Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдээс бусад ой, түүхэн үйл явдал, салбарын болон зарим ажил мэргэжлийн ажилтан, ажилчдын өдөр, энэ хуульд зааснаас бусад олон улсын байгууллагаас дэлхий нийтээр тэмдэглэхээр тогтсон тэмдэглэлт өдрийг Засгийн газар тогтооно” гэж заажээ.

Монгол Улсын төрийн залгамж чанар, үнэт бүрэн эрхийнхээ хүрээнд Монгол Улсын төр, нийгмийн нэрт зүтгэлтэн “Жамсрангийн Самбуугийн мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дээр дурдсан хууль, эрх зүйн хүрээнд Улсын Их Хурлын нэр бүхий гишүүд санаачлан боловсруулсан байна.

1.2.Практик хэрэгцээ, шаардлага

Монгол Улсын төр, нийгмийн нэрт зүтгэлтэн Жамсрангийн Самбуугийн мэндэлсний 130 жилийн ой 2025 онд тохиож байгаатай холбогдуулан эх орны нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх, ард түмний аж амьдралыг дээшлүүлэх, олон улсын харилцааг бэхжүүлэх, энх тайвныг сахин хамгаалах үйлсэд түүний оруулсан үнэтэй хувь нэмэр, амьдрал, үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах шаардлагатай байна.

Жамсрангийн Самбуу бол “Монгол төрийн мэргэн өвөө” хэмээн нэрлэгдэж, ард түмнийхээ гүн хүндэтгэлийг хүлээсэн, өнөөг хүртэл нэр нь бүтэн байгаа төрийн зүтгэлтэн мөн. Үлгэр жишээч төрийн албан хаагч байсан Жамсрангийн Самбуугийн төрийн ажлын өвөрмөц арга барил болон манай орны эдийн засгийн тулгуур салбар болох уламжлалт мал аж ахуйг зөв зохистой эрхлэх талаарх түүний үнэ цэнтэй бүтээл, сургаалыг залуу үеийнхэнд таниулах, эзэмшүүлэх нь чухал ач холбогдолтой байна.

“Жамсрангийн Самбуугийн мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулна.

Хоёр.Тогтоолын төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Тогтоолын төсөл нь 3 заалттай бөгөөд Жамсрангийн Самбуугийн мэндэлсний 130 жилийн ойг 2025 онд тэмдэглэн өнгөрүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт үүрэг болгох асуудлыг тусгана.

Гурав.Тогтоолынн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар

БНМАУ-ын Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн дарга асан, бүрэн эрхт элчин сайд, ХХ зууны төр, нийгмийн нэрт зүтгэлтэн Жамсрангийн Самбуугийн мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлж, түүний алдар гавьяаг мөнхжүүлэх, эх орны нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх, олон улсын харилцааг бэхжүүлэх, энх тайвныг сахин хамгаалах үйлсэд түүний оруулсан үнэтэй хувь нэмэр, амьдрал, үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах боломж бүрдэнэ.

Жамсрангийн Самбуугийн амьдрал, үйл ажиллагааных нь талаар эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулагдаж, ном, баримтат кино бүтээгдэнэ. Жамсрангийн Самбуугийн амьдралын замнал, төрийн ажлын арга туршлага болон уламжлалт мал аж ахуйн талаарх бүтээл, сургаалыг нь төрийн залуу албан хаагчид болон залуу малчдад таниулсанаар тэдэнд сайн арга туршлага, арга барилыг эзэмшүүлж, тэдний чадавхыг бэхжүүлэхэд зохих нөлөө үзүүлнэ.

Тогтоолын төсөл батлагдсаны дараа хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд гаргах нэмэлт хөрөнгийн асуудлыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ.

Дөрөв.Тогтоолын төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаар

Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон холбогдох бусад хууль тогтоомжтой нийцэж байгаа бөгөөд энэхүү тогтоолын төсөлтэй холбогдуулан хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй.

---oOo---

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

“Жамсрангийн Самбуугийн мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар

Жамсрангийн Самбуу Түшээт хан аймгийн Зоригт вангийн хошуу, одоогийн Төв аймгийн Бүрэн сумын нутагт 1895 оны 6 дугаар сарын 25-нд мэндэлжээ. Тэрээр 1903 онд нутгийн сайн бичээч Дугарсүрэн гэж хүнд шавь орж гэрээр бичиг үсэг сурч хошуу тамгын газар бичээч болж, 1950 онд Намын шинэ хүчний сургуульд суралцаж төгсжээ.

Жамсрангийн Самбуу 1912 оноос Нийслэл хүрээний Түмтийн өртөөнд улаач, 1921 оноос Түшээт вангийн хошууны тамгын газар хавсраа бичээч, 1923 оноос Ардын Засгийн газрын Сангийн яаманд гутгаар зэргийн нягтлан бодогч, 1926 оноос тэргүүн зэргийн нягтлан бодогч түшмэл, 1928 онд эрхэлсэн түшмэл, 1930 оноос Богдхаан уулын (одоогийн Төв аймаг) аймгийн дарга, 1931 оноос Өмнөговь аймгийн дарга, 1932 оноос тус аймгийн шүүхийн даргаар ажиллаж байв. 1934-1937 онд Мал тариалангийн яаманд хэлтсийн дарга, 1937-1941 онд БНМАУ-аас ЗСБНХУ-д (хуучин нэрээр) суух Бүрэн эрхт төлөөлөгч, 1941-1946 онд Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд, 1946-1950 онд онд Гадаад явдлын яамны Алс Дорнодын хэлтсийн дарга, 1950-1952 онд БНАСАУ-д суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд, 1952-1953 онд Гадаад яамны орлогч сайд, 1953-1954 онд Монгол-Зөвлөлтийн найрамдлын нийгэмлэгийн орлогч даргаар ажиллажээ.

Тэрээр 1954-1960 онд Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Улсын Их Хурлын дарга, 1960-1972 онд БНМАУ-ын Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн даргаар удаа дараа сонгогдон ажиллахдаа түүний санаачилгаар улсын хөгжил дэвшилтэй холбоотой олон чухал шийдвэр гарсан байна. Үүнээс үзэхэд, Жамсрангийн Самбуу нь Монгол Улсын төрийн анхан, дунд, дээд шатны албыг 60 жилийн турш ээлж дараатай хашсан, эх орныхоо хөгжил дэвшил, гадаад харилцаанд бодитой хувь нэмэр оруулсан төрийн зүтгэлтэн, дипломатч хүн юм.

Жамсрангийн Самбуу 1935, 1937, 1943, 1945, 1958, 1961, 1965, 1971 онуудад “Мал аж ахуй дээр яаж ажиллах тухай ардад өгөх сануулга сургаал”, “Малчдад өгөх зөвлөгөө”, “Малчин ардын амьдрал ахуй, хэв заншлаас” зэрэг 12 бүтээл туурвисан нь манай эдийн засгийн уламжлалт салбар мал аж ахуй эрхлэгчдэд өдгөө ч үнэ цэнтэй гарын авлага хэвээр байна.

Монголын Улсын төрийн тэргүүн байсан Жамсрангийн Самбуугийн хөдөлмөр зүтгэлийг үнэлж БНМАУ-ын хөдөлмөрийн баатар (1968) цол хүртээж, Сүхбаатарын одонгоор дөрвөн удаа, мөн зарим гадаад орны төрийн дээд шагналуудаар шагнасан бол түүний мэргэн ухаан, төрийн ажлын арга туршлага, ур чадварыг нь ард түмэн үнэлж “Монгол төрийн мэргэн өвөө” хэмээн хүндэтгэн нэрлэдэг байжээ.

Төр, нийгмийн нэрт зүтгэлтэн Жамсрангийн Самбуугийн мэндэлсний 130 жилийн ой 2025 онд тохиож байгаатай холбогдуулан манай орны нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх, олон улсын харилцааг бэхжүүлэх үйлсэд түүний оруулсан үнэтэй хувь нэмэр, амьдрал, үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулах зорилгоор “Жамсрангийн Самбуугийн мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.

Жамсрангийн Самбуугийн мэндэлсний 130 жилийн ойг 2025 онд тэмдэглэн өнгөрүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт үүрэг болгох асуудлыг тогтоолын төсөлд тусгасан.

Тогтоолын төслийн талаар Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, Сангийн яамны саналууд болон Шинжлэх Ухааны Академийн дүгнэлтийг хавсаргав.

ТОГТООЛ САНААЧЛАГЧ

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Жамсрангийн Самбуугийн мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар

Жамсрангийн Самбуу Монгол Улсын ХХ зууны түүхэнд чухал байр суурь эзэлсэн, улс орныхоо хөгжил дэвшил, олон улсын харилцаанд үнэтэй хувь нэмэр оруулсан, төрийн ажил үйлсэд чухал үүрэг гүйцэтгэсэн төрийн нэрт зүтгэлтэн юм.

Тэрээр БНМАУ-ын Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн даргаар 18 жил ажиллахдаа олон чухал шийдвэр гаргаж, улс орны хөгжлийг ахиулахад бодитой хувь нэмрээ оруулжээ. Түүнчлэн элчин сайдаар ажиллаж, олон улсын харилцааг бэхжүүлэхийн төлөө идэвх зүтгэлтэй ажилласан нь Монголын дипломат албаны түүхэнд чухал байр суурь эзэлдэг.

Жамсрангийн Самбуу нь төрийн болон дипломат албаны зэрэгцээ олон нийтэд зориулсан үнэ цэнтэй ном, судалгааны бүтээл туурвиж, ард түмэндээ мэдлэг, мэдээлэл түгээхэд чухал үүрэг гүйцэтгэсэн. Тухайлбал, “Мал аж ахуй дээр яаж ажиллах тухай ардад сануулга сургаал” зэрэг бүтээл нь малчдад зориулсан зөвлөгөө, мэдээллийг агуулсан чухал гарын авлага юм.

Монгол Улсын төр, нийгмийн нэрт зүтгэлтэн Жамсрангийн Самбуугийн мэндэлсний 130 жилийн ой 2025 онд тохиож байгаатай холбогдуулан улс орны хөгжил дэвшил болон олон улсын харилцааг бэхжүүлэхэд түүний оруулсан үнэтэй хувь нэмрийг үнэлж, амьдрал, үйл ажиллагааг судлан таниулах, залуу үед сурталчлах ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулах нь чухал ач холбогдолтой байна.

Иймд Жамсрангийн Самбуугийн мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.

Жамсрангийн Самбуугийн мэндэлсний 130 жилийн ойг 2025 онд тэмдэглэн өнгөрүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт үүрэг болгох асуудлыг тогтоолын төсөлд тусгасан.

ТОГТООЛ САНААЧЛАГЧ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар
хот

**Жамсрангийн Самбуугийн алдар гавьяаг
мөнхжүүлэх, түүний мэндэлсний 130 жилийн
ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах
зарим арга хэмжээний тухай**

БНМАУ-ын Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн дарга асан, бүрэн эрхт элчин сайд, ХХ зууны төр, нийгмийн нэрт зүтгэлтэн Жамсрангийн Самбуугийн мэндэлсний 130 жилийн ой тохиож байгаатай холбогдуулан түүний алдар гавьяаг мөнхжүүлэх зорилгоор Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Жамсрангийн Самбуугийн мэндэлсний 130 жилийн ойг 2025 онд тэмдэглэн өнгөрүүлэх талаар дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/ойг тэмдэглэн өнгөрүүлэх бэлтгэл ажлын төлөвлөгөө, хөтөлбөр баталж, зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулан ажиллуулах;

2/Жамсрангийн Самбуугийн эх орны нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх, олон улсын харилцааг бэхжүүлэх, энх тайвныг сахин хамгаалах, төрийн албыг төлөвшүүлэхэд оруулсан үнэтэй хувь нэмэр, түүний амьдрал, үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах;

3/ойг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдуулан эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулах, ном туурвин хэвлүүлэх, баримтат кино бүтээх болон төлөвлөсөн холбогдох бусад арга хэмжээнд шаардагдах зардлыг санхүүжүүлэх арга хэмжээг хууль тогтоомжид заасан эрх хэмжээнийхээ хүрээнд шийдвэрлэх.

2.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо /Ж.Бат-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

Гарын үсэг

**“МОНГОЛ УЛСЫН ТӨР, НИЙГМИЙН НЭРТ ЗҮТГЭЛТЭН ЖАМСРАНГИЙН
САМБУУГИЙН МЭНДЭЛСНИЙ 130 ЖИЛИЙН ОЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭХ
ТАЛААР АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛЫН ТӨСЛИЙГ БОЛОВСРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ
УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

“Монгол Улсын төр, нийгмийн нэрт зүтгэлтэн
Жамсрангийн Самбуугийн мэндэлсний 130
жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах
зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын
тогтоолын төсөл боловсруулах тухай

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын үе үеийн төрийн ажил хэргийн төлөө хүчин зүтгэсэн төр, нийгмийн нэрт зүтгэлтнүүдийн нийгэмд гүйцэтгэсэн үүрэг, оруулсан хувь нэмэр, гавьяаг үнэлэж мөнхжүүлэхийн зэрэгцээ тэдний амьдрал, ажил үйлсийн замнал, арга туршлагыг ирээдүй хойч үедээ таниулан сурталчлах нь чухал ач холбогдолтой билээ.

Төр нийгмийн нэрт зүтгэлтэн Жамсрангийн Самбуугийн амьдрал, ажил үйлсийн замнал нь Монгол Улсын XX зууны хөгжлийн түүхэнд чухал байр суурь эзэлдэг бөгөөд түүний зүтгэл, үйлс нь өнөөдөр ч бидэнд үлгэр дууриалал болж байна. Монгол Улсын төр, нийгмийн нэрт зүтгэлтэн Ж.Самбуугийн мэндэлсний 130 жилийн ой 2025 онд тохиож байгаатай холбогдуулан эх орны нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх, ард түмний аж амьдралыг дээшлүүлэх, олон улсын харилцааг бэхжүүлэх, энх тайвныг сахин хамгаалах үйлсэд түүний оруулсан үнэтэй хувь нэмэр, амьдрал, үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах шаардлагатай байна.

Түүхэн эх сурвалжийн мэдээ мэлтийг үндэслэн Ж.Самбуугийн эрхэлж байсан ажил үйлсийг дөрвөн чиглэлд хуваан авч үзэж болно.

- 1) Төрийн албанд хувь нэмрээ оруулсан нэр цэвэр төрийн зүтгэлтэн. Ж.Самбуу нь Монгол Улсын төрийн зүтгэлтэн бөгөөд 1921 оноос хойш Түшээт вангийн хошууны тамгын газар хавсраа бичээчээр ажиллаж эхэлжээ. Тэрээр Монголын Ардын хувьсгал ялснаас хойш төрийн албанд идэвхтэй оролцож, 1940-өөд оноос БНМАУ-ын Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн дарга болсон. Түүний удирдлага дор Монгол Улс олон чухал шийдвэрүүдийг гаргаж, улс орны хөгжлийг ахиулахад чухал хувь нэмэр болсон.
- 2) Дипломат албанд хувь нэмрээ оруулсан элчин сайд. Ж.Самбуу нь Монгол Улсын дипломат албанд ч идэвх зүтгэлтэй ажилласан. Тэрээр бүрэн эрхт Элчин сайдаар ажиллаж, олон улсын харилцааг хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн.
- 3) Нийтлэл, судалгааны ажил гүйцэтгэсэн мэдээлэл түгээгч судлаач. Ж.Самбуугийн олон нийтэд зориулсан ном, судалгааны материалуудыг бичиж, ард түмэндээ мэдлэг, мэдээлэл түгээхэд чухал үүрэг гүйцэтгэсэн хүн.

Ж.Самбуу 1935-1971 онд “Мал аж ахуй дээр яаж ажиллах тухай ардад өгөх сануулга сургаал”, “Малчдад өгөх зөвлөгөө”, “Малчин ардын амьдрал ахуй, хэв заншлаас” зэрэг 12 бүтээл туурвисан нь манай эдийн засгийн уламжлалт салбар мал аж ахуй эрхлэгчдэд өдгөө ч үнэ цэнтэй гарын авлага хэвээр байна.

Иймд төр, нийгмийн нэрт зүтгэлтэн Жамсрангийн Самбуугийн эрхэлж байсан ажил, үйлс, амьдралын замналыг судлах, үлгэр дуриалалтай арга туршлагыг нь олон нийтэд түгээх зорилгоор түүний мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын Тогтоолын төслийг санаачлан боловсруулах нь зүйтэй гэж үзэв.

УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Ж.Самбуугийн мэндэлсний 130 жилийн ойг тохиолдуулан түүний амьдрал, ажил үйлсийг мөнхжүүлэх хэрэгцээ шаардлагыг тодорхойлохын тулд түүний талаарх түүхэн эх сурвалжийн баримт, мэдээ сэлтэд дүн шинжилгээ хийх, холбогдох эрдэмтэн судлаачидтай уулзаж ярилцах, ШУА-д хүсэлт тавьж дүгнэлт гаргуулах зэргээр урьдчилан тандан судалгааны үнэлгээ хийв.

НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

Монгол Улсын төрийн зүтгэлтэн Ж.Самбуугийн ажил үйлс, амьдарлын замналын талаар эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах, баримтат кино бүтээх, ном бичих замаар замаар улс орны хөгжил дэвшил, ард түмний аж амьдралыг дээшлүүлэх, олон улсын харилцааг бэхжүүлэх, энх тайвныг сахин хамгаалахад түүний оруулсан үнэтэй хувь нэмрийг үнэлж хадгалах, амьдрал, үйл ажиллагааг залуу үед сурталчлан таниулах ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулах зүй ёсны шаардлагатай байна гэж үзсэн болно.

Сүүлийн үеийн зарим судалгаанаас харахад, Ж.Самбуу г бол тухайн үеийн Монголын төрийн тэргүүн байсан бөгөөд түүнийг “Монгол төрийн мэргэн өвөө” хэмээн нэрлэдэг байжээ. Энэ нь түүний мэргэн ухаан, туршлага, улс төрийн чадварыг илтгэж байна.

1.1. Асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлсон байдал:

Шинжилгээнд тулгуурлан Ж.Самбуу бол Монголын XX зууны түүхэнд чухал байр суурь эзэлсэн, улс орныхоо хөгжил дэвшил, олон улсын харилцаанд үнэтэй хувь нэмэр оруулсан нэрт төрийн зүтгэлтэн байсан гэж дүгнэх бүрэн үндэслэлтэй байна.

Иймд “Жамсрангийн Самбуугийн мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлд дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгана:

- ойг тэмдэглэн өнгөрүүлэх бэлтгэл ажлын төлөвлөгөө, хөтөлбөр баталж, зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулан ажиллуулах;
- Ж.Самбуугийн эх орны нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх, олон улсын харилцааг бэхжүүлэх, энх тайвныг сахин хамгаалах, төрийн албыг төлөвшүүлэхэд оруулсан үнэтэй хувь нэмэр, түүний амьдрал, үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах;
- ойг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдуулан эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулах, ном туурвин хэвлүүлэх, баримтат кино бүтээх болон төлөвлөсөн холбогдох бусад арга хэмжээнд шаардагдах зардлыг санхүүжүүлэх арга хэмжээг хууль тогтоомжид заасан эрх хэмжээнийхээ хүрээнд шийдвэрлэх.

Түүнчлэн энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо үүрэг болгохоор төсөлд тусгасан болно.

1.2. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг тодорхойлох:

Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг Монгол Улсын Засгийн газар хариуцан зохион байгуулах бөгөөд холбогдох яам, аймаг, сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, төрийн захиргааны байгууллага, эрдэм шинжилгээний байгууллагын төлөөлөл оролцсон ажлын хэсэг байгуулагдан бэлтгэл ажлыг хангана.

Уг тогтоол гарснаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, хуулийн этгээд байхгүй болно.

1.3. Асуудлыг үүсгэж буй шалтгаан нөхцөл:

Тухайн үеийн төр засгийн зүгээс Ж.Самбуугийн хөдөлмөр зүтгэлийг үнэлж 1968 онд БНМАУ-ын хөдөлмөрийн баатар цол хүртээжээ. Төрийн ахмад зүтгэлтэн Ж.Самбуугийн гэгээн дурсгалыг мөнхжүүлж Төрийн ордны арын цэцэрлэгт хүрээлэнд шарилыг нь онголж, Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн, Бүрэн сумын ерөнхий боловсролын сургууль, Улаанбаатар хотын төвийн нэг гудамжийг түүний нэрэмжит болгож, Бүрэн сумын төв, Төрийн ордоны дэргэд хөшөөг нь босгосон хүнтэтгэл үзүүлж иржээ.

Монгол Улсын төр, нийгмийн нэрт зүтгэлтэн Жамсрангийн Самбуугийн мэндэлсний 130 жилийн ой 2025 онд тохиож байгаатай холбогдуулан улс орны хөгжил дэвшил болон олон улсын харилцааг бэхжүүлэхэд түүний оруулсан үнэтэй хувь нэмрийг үнэлж, амьдрал, үйл ажиллагааг судлан таниулах, залуу үед сурталчлах ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулж, түүний амьдрал, үйл ажиллагааг илүү өргөн хүрээнд судлах, түгээн дэогэрүүлэх шаардлагатай байна.

ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОМЬЁОЛСОН БАЙДАЛ

Улсын Их Хурлын тогтоол нь төр, нийгмийн зүтгэлтэн Ж.Самбуугийн Монгол Улсын түүхэнд гүйцэтгэсэн чухал үүргийг хүндэтгэн үзэж мөнхжүүлэх, түүний өв санааг ирээдүй хойч үедээ өвлүүлэн үлдээх зорилготой юм.

**ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЕРЭГ,
СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ**

№	Хувилбар	Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
1.	Тэг хувилбар	Монгол төрийн залгамж чанар, төрийн шударга зүтгэлтэнд хандах хандлага, үнэлэмж доогуур хэвээр үлдэнэ.	Нэмэлт зардал гарахгүй.	Үр дүнд хүрэхгүй.
2.	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх	Төрийн нэрт зүтгэлтний ажлын арга барил, арга туршлагыг залуу хойч үед таниулан эзэмшүүлэх боломж бүрдэнэ.	Зохих хэмжээний зардал гарна.	Зохих үр дүнд хүрнэ.
3.	Эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах	Төрийн нэрт зүтгэлтний эдийн засгийн тулгуур салбар болох мал аж ахуйн үйлдвэрлэлийг эрхлэн хөтлөх талаарга сургаал, зөвлөмжийг олон нийтэд, малчдад түгээх боломж бүрдэнэ.	Зохих хэмжээний зардал гарна.	Зохих үр дүнд хүрнэ.
4.	Ном, баримтат кино бүтээж олны хүртээл болгох	Төрийн нэрт зүтгэлтний төрийн ажил үйлс, амьдралын замналыг нийтэд хүргэх боломж бүрдэнэ.	Зохих хэмжээний зардал гарна.	Зохих үр дүнд хүрнэ.
5.	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	“Монгол Улсын төр, нийгмийн нэрт зүтгэлтэн Жамсрангийн Самбуугийн мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулах замаар дээр дурдсан арга хэмжээг улсын хэмжээнд зохион байгуулж, зорилгод хүрэх боломжтой.	Зохих хэмжээний зардал гарна.	Үр дүнтэй.

**ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР
НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ**

Аргачлалын 6-д заасны дагуу сонгосон хувилбарын үр нөлөөг Аргачлалд заасны дагуу ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа.

4.1.Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Улс эх орныхоо хөгжилд бодитой хувь нэмэр оруулсан, нэр цэвэр төрийн зүтгэлтэн хэн боловч дараа үеийнхэн болон төрийн зүгээс хүндэтгэлтэй хандах шударга байдал хангагдах эерэг нөлөөтэй.

4.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Мал аж ахуйн үйлдвэрлэлийг эрхлэх талаарх Ж.Самбуугийн зөвлөмжийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр залуу малчдад түгээснээр тэд аж ахуйгаа үр ашигтай эрхлэхэд зохих нөлөө үзүүлнэ.

4.3. Нийгэмд үзүүлэх нөлөө

Төрийн ажил үйлсийг шударгаар эрхлэх талаарх Ж.Самбуугийн арга барилыг төрийн албан хаагчдад таниулснаар төрийн албаны чанар сайжрахад дам нөлөө үзүүлнэ.

4.4. Байгаль орчинд үзүүлэх нөлөө

Байгаль орчинд ямар нэгэн шууд болон шууд бус сөрөг нөлөө үзүүлэхгүй.

4.5. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх

Энэхүү тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээнд нийцэх бөгөөд өнөөдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомжийг аливаа хэлбэрээр зөрчихгүй болно.

ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ

Тогтоолын төсөл батлагдснаар тавьж буй зорилгод хүрэх бөгөөд ойг тэмдэглэн өнгөрүүлэхэд шаардлагатай зохих хэмжээний зардлыг Засгийн газар эрх мэдлийнхээ хүрээнд шийдвэрлэнэ.

Энэхүү тогтоол нь холбогдох хууль тогтоомжид нийцэж байгаа бөгөөд хүний эрх, эдийн засагт, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө нь эрэг хандлагатай байна.

ЗУРГАА. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Энэхүү тогтоол нь төр, нийгмийн зүтгэлтний нэр, ажил үйлсийн сайн өвийг хойч үедээ танилах зорилготой нэг удаагийн шийдвэр тул олон улсын болон бусад хууль, эрх зүйн зохицуулалттай харьцуулах шаардлагагүй.

ДОЛОО. ЗӨВЛӨМЖ

“Монгол Улсын төр, нийгмийн нэрт зүтгэлтэн Жамсрангийн Самбуугийн мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулж батлан гаргах хувилбарыг сонгох нь зүйтэй гэж үзэж байна. Тус тогтоолоор дараах асуудлыг нарийвчлан зохицуулах шаардлагатай байна:

- Ойг тэмдэглэн өнгөрүүлэх бэлтгэл ажлын төлөвлөгөө, хөтөлбөр баталж, зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулан ажиллуулах;

- Ж.Самбуугийн эх орны нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх, олон улсын харилцааг бэхжүүлэх, энх тайвныг сахин хамгаалах, төрийн албыг төлөвшүүлэхэд оруулсан үнэтэй хувь нэмэр, түүний амьдрал, үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах;
- Ойг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдуулан эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулах, ном туурвин хэвлүүлэх, баримтат кино бүтээх болон төлөвлөсөн холбогдох бусад арга хэмжээнд шаардагдах зардлыг санхүүжүүлэх арга хэмжээг хууль тогтоомжид заасан эрх хэмжээнийхээ хүрээнд шийдвэрлэх.

Харьцуулалтын үр дүнг харгалзан Хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбар нь зорилгод хүрэх боломжтой цорын ганц оновчтой хувилбар гэж дүгнэж байна.

ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

(Хүснэгт 1)

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж буй эсэх	1.1.Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх			
	1.1.1. Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм	Үгүй	-
	1.1.2. Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	-
	1.1.3. Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ мөн бол олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх	Тийм	Үгүй	-
	1.2.Оролцоог хангах			
	1.1.4. Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм	Үгүй	-
	1.1.5.Ялангуяа зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	-
	1.3.Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал хариуцлага			
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм	Үгүй	-
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, ын хүний эрхийн механизмаас тухайн асуудлаар өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	-
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм	Үгүй	-
2.Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1.Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах бол энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх	Тийм	Үгүй	
	2.2.Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Тийм	Үгүй	-

3.Эрх агуулагч	3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	-
	3.2.Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	-
	3.3.Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Тийм	Үгүй	-
	3.4.Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй	Тийм	Үгүй	-
4.Үүрэг хүлээгч	4.1.Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	-
5.Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1.Жендерийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм	Үгүй	-
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм	Үгүй	-

ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ (Хүснэгт 2)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Мэдээлэх үүргийн улмаас үүсэж байгаа захиргааны зардлын ачаалал	1.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх,тайлан гаргах гэх мэт) бий болгох эсэх	Тийм	Үгүй	-
2.Өмчлөх эрх	2.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	Тийм	Үгүй	-
	2.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	-
	2.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	-
3.Инноваци болон судалгаа шинжилгээ	3.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм	Үгүй	-
	3.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм	Үгүй	-
4.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	4.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	-
	4.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	-

	4.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	-
5.Тодорхой бүс нутаг, салбарууд	5.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм	Үгүй	-
	5.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	-
	5.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	-
6.Төрийн захиргааны байгууллага	6.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Өчүүхэн бага
	6.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Тийм	Үгүй	-
	6.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм	Үгүй	-
7.Макро эдийн засгийн хүрээнд	7.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	-
	7.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм	Үгүй	-
	7.3.Инфляци нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	-
8.Олон улсын харилцаа	8.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	-

НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ (Хүснэгт 3)

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Тийм	Үгүй	-
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх	Тийм	Үгүй	-
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	-
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	-
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	-
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	-
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	-
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Тийм	Үгүй	-
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Тийм	Үгүй	-
3.Нийгмийн тодорхой	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	-

бүлгийг хамгаалах асуудал	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт	Тийм	Үгүй	-
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	-
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	-
	4.2.Төрийн Байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	-
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	-
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	-
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	-
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт,өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	-
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	-
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	-
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	-
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	-
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	-
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	-
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	-
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	-
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	-
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	-
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	-
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	-
	8.2.Хэл, соёлын ялгаатай	Тийм	Үгүй	-

	байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх			
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	-

БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

(Хүснэгт 4)

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	-
2.Зам тээвэр,	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Тийм	Үгүй	-
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	-
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	-
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	-
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Тийм	Үгүй	-
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	-
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	-
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	-
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	-
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	-
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	-
5.Хөрсний Бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	-
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	-
6.Газрын Ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Тийм	Үгүй	-
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	-
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	-
7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхыг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Тийм	Үгүй	-
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	-

---oo0oo---

**“МОНГОЛ УЛСЫН ТӨР, НИЙГМИЙН НЭРТ ЗҮТГЭЛТЭН ЖАМСРАНГИЙН
САМБУУГИЙН МЭНДЭЛСНИЙ 130 ЖИЛИЙН ОЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭХ
ТАЛААР АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ
СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү үнэлгээг Улсын Их хурлын гишүүн С.Эрдэнэболд нарын боловсруулсан “Монгол Улсын төр, нийгмийн нэрт зүтгэлтэн Жамсрангийн Самбуугийн мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлд Хууль тогтоомжийн тухай хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг илрүүлэн, хуулийн зүйл, заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулахад зөвлөмж өгөх зорилгоор гүйцэтгэлээ.

Үнэлгээ хийхээр сонгож авсан хууль тогтоомжийн төсөл нь тогтоолын төсөл хэлбэрээр боловсруулагдсан байна. “Монгол Улсын төр, нийгмийн нэрт зүтгэлтэн Жамсрангийн Самбуугийн мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /цаашид “тогтоолын төсөл” гэх/-ийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал”-д /цаашид “Аргачлал” гэх/ заасны дагуу дараах үе шатаар хийлээ.

- ✓ Шалгуур үзүүлэлтийг сонгох;
- ✓ Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
- ✓ Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
- ✓ Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

**ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ
СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ**

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ тогтоолын төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан Аргачлалын 2.9-д заасныг үндэслэн 6 шалгуур үзүүлэлтээс дараах 4 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал
2. Практикт хэрэгжих боломж
3. Ойлгомжтой байдал
4. Харилцан уялдаа зэрэг болно.

1. Зорилгод хүрэх байдал:

Энэхүү үнэлгээний үндсэн зорилго нь тухайн тогтоолын төслийн зохицуулалт анх дэвшүүлсэн зорилго буюу тулгамдсан бэрхшээлийг шийдвэрлэж чадах эсэхийг тогтоох билээ. Иймд тогтоолын төслийн зохицуулалт нь тогтоолын төслийн үзэл баримтлал буюу тогтоолын төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн эсэх, мөн түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц зохицуулалтын хувилбарыг агуулсан эсэхийг тогтоох зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

2. Практикт хэрэгжих боломж:

Энэхүү тогтоолын төсөлд төр, нийгмийн нэрт зүтгэлтний ойг тэмдэглэх, амвьдрал, ажил үйлсийн сайн арга туршлагыг түгээн дэлгэрүүлэх, таниулах талаар олон нийтийн хандах хандлагыг харгалзан тус шалгуур үзүүлэлтийг сонгосон.

3. Ойлгомжтой байдал:

Тогтоолыг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектийн хувьд ойлгомжтой байх нь хэрэгжилтийн үр дүнд шууд нөлөөлдөг. Хууль тогтоомжийн тухай хуульд зааснаар тогтоолын төсөл нь бүтэц, хэлбэрийн хувьд логик дараалалтай, хэл зүй, найруулгын хувьд тодорхой, ойлгоход хялбараар томъёологдсон байх шаардлага тавигддаг.

Энэхүү тогтоолын төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянан тогтоох зорилгоор энэхүү шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

4. Харилцан уялдаа:

Тогтоолын төслийн эх бичвэр нь хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомж болон төсөлд тусгагдсан зохицуулалт нь өөр хоорондоо зөрчилгүй байх, хуулиар үүрэг хүлээсэн субъектүүдийн чиг үүрэг давхардал, зөрчилдөөнгүй байх шаардлагатай. Иймд тогтоолын төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуульд заасан агуулгын шаардлага хангасан эсэхийг шалгах зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонгож байна.

Түүнчлэн тогтоолын төсөлд тусгагдсан зохицуулалтын хүрээнд хамрагдах этгээд /иргэн, хуулийн этгээд/ хүлээн зөвшөөрөх эсэхийг тодруулах зорилт бүхий “хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлгээ хийх шаардлагагүй гэж үзсэн болно. Мөн дээрх үндэслэлээс гадна тухайн тогтоолын төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог тусгайлан хийх тул цаг хугацаа, нөөцийн хэмнэлт хийх үүднээс “зардал тооцох” шалгуур үзүүлэлтийг сонгоогүй болно.

ГУРАВ. ТОГТООЛЫН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

Сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үр нөлөөг үнэлэхэд хамруулах хэсэг, түүнийг шалгах хэрэгслийг дараах байдлаар тогтоолоо. Үүнд:

№	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Шалгуур үзүүлэлтийг сонгох
1.	Зорилгод хүрэх байдал	Тогтоолын төслийн холбогдох зохицуулалт	“Зорилгод хүрэх байдал” нь тухайн тогтоолын төслөөр тавьж байгаа зорилгодоо хүрч чадах эсэхийг тооцон судалдаг шалгуур үзүүлэлт юм. Тогтоолын төслийн үзэл баримтлалд дэвшүүлсэн зорилтыг хангах эсэхэд дүн шинжилгээ хийх.
2.	Практикт хэрэгжих боломж	Төсөлд шинээр нэмэгдсэн зүйлүүдэд заасан зохицуулалт хэрэгжих боломжтой эсэхийг үнэлэх	“Практикт хэрэгжих боломж” гэсэн шалгуур үзүүлэлтийн боломж хүрээнд тухайн тогтоолын төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломжтой эсэхийг, тухайлбал, тогтоолын төслийг хэрэгжүүлэх этгээд байгаа эсэх, тэдгээр этгээдэд тухайн хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж, бололцоо (санхүү, хүний нөөц зэрэг) байгаа эсэхийг шалгаж тооцно. Энэхүү үнэлгээний хүрээнд практикт хэрэгжих боломж гэсэн шалгуур үзүүлэлтийг сонгон үнэлгээ хийнэ.
3.	Ойлгомжтой байдал	Тогтоолын төсөлд зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд тогтоолын төслийн зохицуулалт түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектүүдийн хувьд ойлгомжтой, логик дараалалтайгаар боловсруулагдсан эсэхийг шалгана. Хууль тогтоомжийн тухай хуулийн 24, 28, 29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах
4.	Харилцан уялдаа	Тогтоолын төсөлд зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн тогтоолын төслийн зүйл, заалт өөр хоорондоо болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомжтой нийцсэн эсэх, мөн төрийн байгууллагын чиг үүрэгтэй давхардсан, зөрчилдсөн эсэх, тухайн чиг үүргийг төрийн байгууллага зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай эсэх, уг чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх боломжтой эсэхийг шалгана.

			Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1, 29.1.5, 29.1.7, 29.1.10-т болон Аргачлалын 4.10-т заасан шаардлага, шалгуурыг хангасан байдлыг шалгах
--	--	--	---

ДӨРӨВ. ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ТООЦСОН БАЙДАЛ

1. Зорилгод хүрэх байдлыг хангасан эсэх:

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд тогтоолын төслийн үзэл баримтлалд тусгасан тогтоолын төсөл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад тогтоолын төслийн зорилго, зохицуулалтууд нь нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх үүднээс тогтоолын төслийн үзэл баримтлалтай танилцаж, үзэл баримтлал болон тогтоолын төслийн зорилго, түүнийг хангахад чиглэсэн зохицуулалтуудыг харьцуулах байдлаар дүн шинжилгээ хийнэ.

Тогтоолын төслийн үзэл баримтлал, хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ, агуулгад дүн шинжилгээ хийж үзвэл:

“Жамсрангийн Самбуугийн мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлд дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгана:

- ойг тэмдэглэн өнгөрүүлэх бэлтгэл ажлын төлөвлөгөө, хөтөлбөр баталж, зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулан ажиллуулах;
- Ж.Самбуугийн эх орны нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх, олон улсын харилцааг бэхжүүлэх, энх тайвныг сахин хамгаалах, төрийн албыг төлөвшүүлэхэд оруулсан үнэтэй хувь нэмэр, түүний амьдрал, үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах;
- ойг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдуулан эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулах, ном туурвин хэвлүүлэх, баримтат кино бүтээх болон төлөвлөсөн холбогдох бусад арга хэмжээнд шаардагдах зардлыг санхүүжүүлэх арга хэмжээг хууль тогтоомжид заасан эрх хэмжээнийхээ хүрээнд шийдвэрлэх.

Түүнчлэн энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо үүрэг болгохоор төсөлд тусгасан болно.

2. Практикт хэрэгжих боломжтой эсэх:

Шалгуур үзүүлэлтийн хүрээнд тогтоолын төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломж байгаа эсэхийг, тухайлбал хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээд байгаа эсэх, уг этгээдэд тухайн хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломжтой эсэхийг шалгахад энэ шалгуурыг сонгов.

Түүхэн эх сурвалж, ШУА-ийн дүгнэлт, Засгийн газрын санал, Самбуу судлаач эрдэмтдийн санал дүгнэлтийг нэгтгэн судалж, тогтоолын төслийг эцэслэн боловсруулснаар практикт хэрэгжих боломж бүрдэнэ.

3. Ойлгомжтой байдлыг хангасан эсэх:

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл боловсруулалтын хувьд Хууль тогтоомжийн тухай хуулийн 26, 28, 29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах байдлаар үнэлгээг гүйцэтгэлээ. Мөн тогтоолын төсөлд холбогдох байгууллагуудаас ойлгомжтой болгох чиглэлээр ирүүлсэн санал байгаа эсэхийг нягтлан, дүн шинжилгээ хийсэн болно.

- ✓ Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасан хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийн хэлбэрээр бичигдсэн хуульд заасан шаардлагыг хангасан.
- ✓ Тогтоолын төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан хуулийн бүтэц, хэлбэрт нийцсэн байна.
- ✓ Тогтоолын төсөлд холбогдох эрдэмтэд, байгууллагаас ирүүлсэн саналд үндэслэн төслийн бичвэрийн томъёоллын ойлгомжтой байдал, логик уялдааг сайжруулсан.

1. Харилцан уялдаатай байдлыг хангасан эсэх:

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд тогтоолын төслийг аргачлалд тусгасан тогтоолын төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар уялдаа холбоог шалгахын тулд тогтоолын төслийг бүхэлд нь авч үзэхээр тооцлоо.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д дурдагдсан нийтлэг шаардлагуудаас харилцан уялдаатай холбогдох 29.1.1, 29.1.5, 29.1.7-т заасан нийтлэг шаардлагууд болон Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын 4.10-т заасан шалгах хэрэгслийн дагуу үнэллээ:

- Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан эсэх:

д/д	Шалгах асуулт	Шаардлагыг хангасан эсэх
1.	29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх:	Монгол Улсын Үндсэн хуульд заасан зарчмыг хангахад чиглэсэн бөгөөд ямар нэгэн байдлаар зөрчилдөөгүй байна.

2.	29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх.	Төслийн зүйл, хэсэг, заалт хоорондоо зөрчилдөөгүй байна.
3.	29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх,	Энэхүү тогтоолын төслийн зүйл, заалт бусад хуулиудтай давхардаагүй.

- Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын 4.10-т заасан уялдаа холбоог шалгах хэрэгсэлд дурдагдсан шалгуурыг хангасан эсэх:

№	Асуулт	Хариулт	Дүн шинжилгээ
1.	Тогтоолын төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх:	Тийм	Тогтоолын төслийн зохицуулалт нь үзэл баримтлалд тусгагдсан зорилтыг бүрэн хангаж байна.
2.	Тогтоолын төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх.	Тийм	Энэхүү шаардлагыг хангасан гэж үзэж байна.
3.	Тогтоолын төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх	Тийм	Энэхүү шаардлагыг хангасан гэж үзэж байна.
4.	Тогтоолын төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх	Тийм	Зарчмын зөрүүтэй ямар нэгэн асуудал дүн шинжилгээний хүрээнд илрээгүй болно.
5.	Тогтоолын төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх	Үгүй	Хяналтаар ямар нэгэн зөрчилтэй зохицуулалт илрээгүй.
6.	Тогтоолын төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх	Тийм	Тогтоолын төслийг хэрэгжүүлэгч субъектүүдийн эрх үүргийг ялган тодорхойлсон байна.
7.	Тогтоолын төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх	Үгүй	Тогтоолын төсөлд байх бүхий л зохицуулалтыг тусгасан гэж ойлгож байна.
8.	Тогтоолын төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх.	Үгүй	Хяналтаар ямар нэгэн зөрчилтэй зохицуулалт илрээгүй.
9.	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх	Үгүй	Хяналтаар ямар нэгэн зөрчилтэй зохицуулалт илрээгүй.
10.	Тогтоолын төслийн зүйл, заалт жендерийн эрх тэгш байдлыг хангасан эсэх	Тийм	Тогтоолын төсөлд тусгайлан зохицуулалт тусгагдаагүй бөгөөд энэ асуудлыг Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хүрээнд зохицуулах боломжтой.

11.	Тогтоолын төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	Үгүй	Хяналтаар энэ төрлийн зөрчил илрээгүй.
12.	Тогтоолын төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх	Тийм	Тухайн тогтоолыг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг Зөрчлийн тухай хуулиар зохицуулагдсан болно.

Энэхүү шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийж үзэхэд энэхүү тогтоолын төслийн зүйл хоорондоо болон Үндсэн хууль, бусад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжтой зөрчилдөөгүй, үүрэг хүлээсэн байгууллага, албан тушаалтнуудын чиг үүрэгт давхардал үүсгээгүй байна.

ТАВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

Үнэлэлт, дүгнэлт

Тогтоолын төслийн бүтэц зохицуулах харилцаа, хамрах хүрээ, агуулгыг дүн шинжилгээг Хууль тогтоомжийн тухай хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу хийв.

“Жамсрангийн Самбуугийн мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлд тус ойг тэмдэглэн өнгөрүүлэх бэлтгэл ажлын төлөвлөгөө, хөтөлбөр баталж, зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулан ажиллуулах, арга хэмжээнд шаардагдах зардлыг санхүүжүүлэх арга хэмжээг хууль тогтоомжид заасан эрх хэмжээнийхээ хүрээнд шийдвэрлэхийг Монгол Улсын Засгийн газарт үүрэг болгох зохицуулалт тусган боловсруулсан байна.

Зөвлөмж

Нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөөн төр нийгмийн нэрт зүтгэлтний ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд тэдний сайн арга туршлага, өвийг хойч үедээ таниулах ажлыг Засгийн газар зохион байгуулах нь нийгмийн үр нөлөөний хувьд ач холбогдолтой гэсэн зөвлөмжийг өгч байна.

**“МОНГОЛ УЛСЫН ТӨР, НИЙГМИЙН НЭРТ ЗҮТГЭЛТЭН ЖАМСРАНГИЙН
САМБУУГИЙН МЭНДЭЛСНИЙ 130 ЖИЛИЙН ОЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭХ
ТАЛААР АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦОО
ХИЙСЭН ТАЙЛАН**

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4-р хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу “Жамсрангийн Самбуугийн мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотой зардлын тооцоог боловсрууллаа.

1.1. Зардлыг тооцоо:

Ойг зохион байгуулах зардал (төгрөгөөр)

№	Зардлын төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал	Нийт зардал
1	Ж.Самбуугийн 130 жилийн ойд зориулсан Эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах	Удаа	1	25,000,000.00	25,000,000.00
2	Жамсрангийн Самбуу (Судалгааны баримтын сан) ном хэвлэж гаргах	х.х.-ширхэг	18 х.х. 500 ш.	8,500.00	4,250,000.00
3	“Монгол төрийн мэргэн өвөө” номыг шинэчлэн туурвиж хэвлүүлэх	х.х.-ширхэг	18 х.х. 1000 ш.	9,000.00	9,000,000.00
4	Ж.Самбуугийн бүтээлийн эмхэтгэл ном хэвлэж гаргах	х.х.-ширхэг	18 х.х. 1000 ш.	9,000.00	9,000,000.00
5	“Ж.Самбуугийн амьдралын замнал” сэдэвт баримтат кино бүтээх	ширхэг	1	36,000,000.00	36,000,000.00
6	Ном, кино зохиогчдын урамшуулал	Хүн	6	3,000,000.00	18,000,000.00
7	УИХ-ын гишүүдийн дунд Ж.Самбуугийн нэрэмжит шатрын тэмцээн зохион байгуулах	удаа	1	5,000,000.00	5,000,000.00
8	Нэгдсэн арга хэмжээний зардал	удаа	1	35,000,000.00	35,000,000.00
9	Сурталчилгааны зардал	удаа	6	1,500,000.00	9,000,000.00
	Дүн				150,250,000.00

“Жамсрангийн Самбуугийн мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлд тусгагдсан арга хэмжээг зохион байгуулахад нийт 150,250,000.00 төгрөг шаардлагатай байна.

---oo0oo-

“ЖАМСРАНГИЙН САМБУУГИЙН МЭНДЭЛЭСНИЙ 130 ЖИЛИЙН ОЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭХ ТАЛААР АВАХ
ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСӨЛД ИРҮҮЛСЭН САНАЛЫН
НЭГТГЭЛ.

Хэлэлцүүлэг:
Ажлын хэсгийн хурал:

№	Санал гаргасан хэлбэр	Санал гаргасан хүн	Гаргасан санал	Саналыг тусгасан эсэх	Тогтооллын төсөлд тусгасан байдал
1.	Засгийн Газрын хэрэг эрхлэх газар	Монгол Засгийн газрын хуралдаан	Жамсрангийн Самбуугийн мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх асуудлыг Шинжлэх ухааны академийн дүгнэлт, соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааныс төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар шийдвэрлэхээр байгааг анхаарах нь зүйтэй гэж үзлээ.	Тийм	Тус газруудаас санал авсан.
2.	Монгол Улсын Шинжлэх Ухааны Академи	Ерөнхийлөгчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч, академич Б.Авид	ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн 2024 оны 10 дугаар сарын 22 -ны өдрийн 01/179 тоот албан бичгийн хавсралтаар Жамсрангийн Самбуугийн мэндэлсний 130 жилийн ойг 2025 онд тэмдэглэх саналыг дэмжсэн байна.	Тийм	Тус тогтоолын төсөлд тусгасаны дагуу Жамсрангийн Самбуугийн мэндэлсний 130 жилийн ойг 2025 онд тэмдэглэнэ.
3.	Монгол Улсын Соёл, Спорт, Аялал жуулчлал,	Монгол Улсын Соёл, Спорт, Аялал жуулчлал,	Жамсрангийн Самбуугийн мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх асуудлыг зарчмын хувьд дэмжиж байгаа	Тийм	Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны болон нэгдсэн

	Залуучуудын яам	Залуучуудын яамны сайд Ц.Номин	бөгөөд Засгийн газрын 2019 оны 204 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралтаар баталсан “Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэн өнгөрүүлэх журам”-д заасны дагуу Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлэх саналтай байна.		хуралдаанаар хэлэлцүүлэх талаар тогтоолын төсөл өргөн мэдүүлнэ.
4.	Монгол Улсын Сангийн яам	Б.Жавхлан	Засгийн газрын санал, дүгнэлтийн төслийг бэлтгүүлэхээр хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ гэж заасны дагуу саналыг Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга Н.Учралд хүргүүлсэн	-	

---oo0oo---



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: http://www.mof.gov.mn

2024. 09. 05 № 01/7385.
танай _____-ны № _____-т

Албан бичиг хүргүүлэх тухай

Монгол Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболдоос “Монгол Улсын төр, нийгмийн нэрт зүтгэлтэн Жамсрангийн Самбуугийн мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулан, санал авахаар ирүүлсэн байна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт “Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн санаачилсан хууль тогтоомжийн төслөө түүний үзэл баримтлал, танилцуулга, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан, эсхүл тухайн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн, хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлсэн, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийсэн тайлангийн хамт санал, дүгнэлт авахаар Засгийн газарт хүргүүлнэ.” гэж, мөн хуулийн 21.2 дахь хэсэгт “Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хууль тогтоомжийн төслийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын гурван өдрийн дотор Засгийн газрын санал, дүгнэлтийн төслийг бэлтгүүлэхээр хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.” гэж тус тус заасан байна.

Иймд дээрх Улсын Их Хурлын тогтоолын төслийг Танд хүргүүлж байна.

Хувийг: Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд Танаа

Хүндэтгэсэн,

Б.ЖАВХЛАН

9762003188



МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ

ШУА-ийн төв байр, Энхтайваны өргөн чөлөө 546,
13 дугаар хороо, Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, 13330
Утас/Факс: (976-51) 26 22 47, (976-51) 26 36 62,
Цахим шуудан: info@mas.ac.mn, Цахим хуудас: www.ac.mn


2024.10.22 № 1/360

танай 2024.10.03 -ны № 444-03/3718-т

Албан бичгийн хариу

Монгол Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд таны санаачлан боловсруулсан Төр, нийгмийн нэрт зүтгэлтэн "Жамсрангийн Самбуугийн мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолын төсөлтэй танилцаж, ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгээс ирүүлсэн саналыг үүгээр хүргүүлж байна.

ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ, АКАДЕМИЧ



Б.АВИД

2324900651

ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн
2024 оны 10-р сарын 24-ны өдрийн
01/11 тоот албан бичгийн хавсралт

9018090238 9095772

ТӨР, НИЙГМИЙН НЭРТ ЗҮТГЭЛТЭН ЖАМСРАНГИЙН САМБУУГИЙН МЭНДЭЛСНИЙ 130 ЖИЛИЙН ОЙГ ТЭМДЭГЛЭХ ТУХАЙ САНАЛ

XX зууны Монгол Улсын төр, нийгмийн нэрт зүтгэлтэн, дипломатч Жамсрангийн Самбуу (1895-1972)-гийн мэндэлсний 130 жилийн ой 2025 онд тохиож байна.

Ж.Самбуу нь 1895 онд Түшээт хан аймгийн Говь түшээ гүний хошууны Гурван хүрийн дэнж хэмээх газар төрсөн. Тэрээр найман наснаас эхлэн өвгөн бичээч Дугарсүрэн гэгчид шавь орж бичиг үсэг заалгасан байна.

1921 оны хувьсгалын үйл хэрэгт оролцож, тайж Бадрахын цэргийн хороонд бичээчийн үүрэг гүйцэтгэж, монгол орны өмнө хязгаарыг хятадын гамин цэргээс чөлөөлөх үйлсэд оролцож байв. 1922 онд МАН-д элсэж, 1923 оноос Сангийн яаманд бичээч, тал бичээч, нягтлан бодох, тэргүүн зэргийн нягтлан бодох бөгөөд Улсын орлого зарлагын салааны эрхлэгч, эрхэлсэн түшмэлээр дэвшин ажиллажээ.

Ж.Самбуу нь 1929 оны 5 дугаар сард Богд хан уулын аймгийн даргаар томилогдож, МАХН-ын VII их хурлын шийдвэрээр Богд хан уулын аймгийг өөрчлөн шинэчлэх бэлтгэл ажлыг удирдан зохион байгуулж байв. Мөн шинээр Өмнөговь аймаг байгуулах ажлыг Д.Лосолын хамт удирдан зохион явуулах НТХ, Засгийн газрын төлөөлөгчөөр томилогдон ажиллаж, 1931 онд Өмнөговь аймгийн даргаар сонгогдсон байна. 1932-1934 онд Өмнөговь аймгийн шүүхийн дарга, Төв аймгийн шүүхийн орлогч даргаар ажиллаж, 1934-1937 оны сүүлч хүртэл БНМАУ-ын Засгийн газрын шийдвэрээр Өмнөговь аймгийн орлогч дарга, Мал, тариалангийн яамны Мал, хадлангийн хэлтсийн даргаар ажиллажээ. 1937 оны 12 дугаар сард БНМАУ-аас ЗСБНХУ-д суух Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайдаар томилогдон ажиллажээ. 1946-1950 онд Гадаад явдлын яамны Дорнодын хэлтсийн даргаар ажиллаж, 1950-1952 онд Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улсад суух Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайдаар томилогдон ажиллав. 1953 онд Гадаад явдлын яамны сайд, Монгол-Зөвлөлтийн найрамдлын нийгэмлэгийн орлогч даргаар ажиллаж, 1954 онд хуралдсан БНМАУ-ын Ардын Их Хурлын 2 дахь удаагийн сонгуулийн I чуулганаас Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн даргаар сонгогдож 1972 он хүртэл тасралтгүй 18 жил ажилласан байна.

Ж.Самбуу нь БНМАУ-ын төрийн тэргүүнээр ажилласан жилүүдэд монгол оронд орчин үеийн соёл иргэншлийн ололт нэвтэрч, хүн ардын эрдэм боловсрол, өнөөгийн хөгжил дэвшлийн тулгуур үндсийг тавьсан билээ. Ардын аж ахуй, соёл-хүмүүжлийн үүрэг эрс дээшилж, үндсэн хууль, бусад гол гол хуулиудыг шинэчлэн боловсруулж баталснаар монгол оронд соёл, боловсрол, аж үйлдвэр, цааз эрхэмжийн нэгдсэн тогтолцоог бий болгоход чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

Ж.Самбуу нь мал сүргийг өсгөн хөгжүүлэх явдалд ихээхэн санаачилга гаргаж, мал маллах арга, ажиллагааны талаар "Мал аж ахуй дээр яаж ажиллах талаар ардуудад өгөх сануулга, зөвлөмж" (1945), "Малчдад өгөх зөвлөгөө" (1956), "Малчин

ардын амьдрал ахуй, хэв заншлаас" (1971) зэрэг бүтээлүүд нь нийт малчид, хөдөө аж ахуйн мэргэжилтнүүдийн нэг чухал гарын авлага болсоор ирсэн билээ. Түүнчлэн "Шашин ба лам нарын асуудал" (1961), "Амьдралын замналаас" (1967) (2 дэвтэр) зэрэг бүтээлүүд нь өдгөө ч шинжлэх ухааны ач холбогдолтой хэвээр байна.

Жамсрангийн Самбуугийн XX зууны Монгол Улсын төр, нийгэм-эдийн засаг, олон улсын харилцааг хөгжүүлэх үйлсэд оруулсан хувь нэмэр, түүний алдар гавьяаг олон нийтэд таниулах шаардлагатай билээ.

Иймд төр нийгмийн нэрт зүтгэлтэн, дипломатч Жамсрангийн Самбуугийн мэндэлсний 130 жилийн ойг 2025 онд тэмдэглэх саналыг дэмжиж байна.

ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн
Ойрхи үеийн түүхийн салбар